



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 23/04

Улаанбаатар хот

Аялал жуулчлалын салбарын цаг үеийн асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

“Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар дараах арга хэмжээг шуурхай авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Үндэсний хорооны гишүүдэд даалгасугай.

1.1 Өвлийн аялал жуулчлалыг дэмжих, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор өвлийн аялал жуулчлалын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин нарт,

1.2 Өвлийн аялал жуулчлалын төлөвлөгөөнд туссан олон улсын болон дотоодын нислэгийн тоо давтамжийг хадгалж, нислэгийн тасалбарын үнийг хөнгөлөх асуудлыг судлаж, шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод,

1.3 Өвлийн улиралд үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын бааз дахь барилга байгууламжийн дулааны асуудлыг цахилгаанаар шийдсэн аж ахуйн нэгжид цахилгааны шөнийн тарифт хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд,

1.4 “Мазаалай” мөсөн наадмын бүтээн байгуулалтад шаардагдах хоёр тэрбум төгрөгийн зардлыг холбогдох эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд, маркетинг сурталчилгаа, зохион байгуулалтын ажилд шаардагдах хоёр тэрбум төгрөгийн зардлыг батлагдсан төсвийн багц болон бусад эх үүсвэрээс шийдвэрлэж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт,

2. Аялал жуулчлалын бүс нутгууд болон авто замын дагуу барьж байгуулах ариун цэврийн байгууламжийн нэгдсэн менежмент, оновчтой технологийн шийдэл, стандартын талаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг Үндэсний хорооны гишүүдэд даалгасугай.

2.1 Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бодлогын хүрээнд шинээр барихаар төлөвлөж буй ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолборыг төрөөс боломжит дэмжлэг үзүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах, үйл ажиллагааны менежментийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн байгууллагад хариуцуулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт,

2.2 Гол чиглэлийн авто зам дагуу 65 байршилд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагуудад ногоон зээлийн дэмжлэг үзүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн сайд С.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт,

2.3 Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын 84 байршилд бага хүчин чадлын ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэг байгуулах ажлын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд,

3. 2024 оны эвентүүдийн цагалбарыг батлах, зарлах арга хэмжээг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин нарт,

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Үндэсний хорооны дараагийн хурлаар биелэлтийг танилцуулахыг Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны дэд дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ОЮУН-ЭРДЭНЭ